**ГАРЧИГ**

***НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА......2***
***ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ . 7***
***ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ......22***
***ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....24***
***ТАВ.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ......27***
***ЗУРГАА.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ......27***
***ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ......28***
***НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ......37***
***ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР......53***
***АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..63***
***ДҮГНЭЛТ......66***

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

*Зураг 1. Төсөл хэрэгжих газрын топо зураг*.....5
*Зураг 2. Тоног төхөөрөмжийн дамжлагын схем* .....6
*Зураг 3. Орчины сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд тээврийн хэрэгсэл явах карьерийн зам дээр хайрга асгаж тэгшилэх ажилын явц*.....7
*Зураг 4. Ажилчдын байрыг засварлаж сайжруулсан* .....8
*Зураг 5.Цайны газрын хуучин шинэ байр*.....9
*Зураг 6.Ажилчдын усанд орох душ барьж байгаа ажлын явц*.....9
*Зураг 7. Ус ашиглах гэрээ*.....11
*Зураг 8. Ус ашиглах эрхийн бичиг*.....12
*Зураг 9.Ус ашиглуулах дүгнэлт* .....15
*Зураг 10. Мэргэжлийн байгууллагаар бохир ус соруулж тээвэрлэсэн* .....17
*Зураг 11. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл* .....18
*Зураг 12. Хаягдал ус зайлуулах гэрээ*.....21
*Зураг 13.Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байдал.* .....22
*Зураг 14.бэлтгэл ажил үр цацах ажилын хэсгээс* .....23
*Зураг 15.Биологийн нөхөн сэргээлт хийсэн байдал* .....24
*Зураг 16.Орон нутгийн замын эвдрэлийг засварлаж тэгшилж байгаа ажлын явц.* .....25
*Зураг 17. Мод тарьсан байдал*.....26
*Зураг 18. Хог хаягдлын цэг* .....28
*Зураг 19. Аюултай хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ* .....31
*Зураг 20. Хог хаяглал цуглуулах, тээвэр гэрээ*.....35
*Зураг 21. Хог хаягдал ачуулсан зарлагын баримт* .....36
*Зураг 22. Онцгой байдлын газраас Гамшигийн үеийн сургалт хийсэн* .....38
*Зураг 23. 2025 оны ХАБЭА сургалтын төсөв* .....41
*Зураг 24. Ажилын хувц авсан баримт* .....42
*Зураг 25. Ажилчдын хувцас, хамгаалах хэрэгсэл авсан төлбөрийн баримтууд* .....43
*Зураг 26. Аюулгүй байдлыг хангах тэмдэг тэмдэглэгээг байршуулсан байдал*.....45
*Зураг 27. Уурхайн талбай дээр аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал*..46
*Зураг 28. 2024 онд хийгдсэн ХАБЭА сургалтын хөтөлбөр* .....48
*Зураг 29. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан баримт, гэрээ* .....52
*Зураг 30. Усны шинжилгээний төлбөр*.....53
*Зураг 31. Агаар, дуу чимээний шинжилгээний хариу*.....54

*Зураг 32. Хөрсний шинжилгээний хариу* ........................................ 56
*Зураг 33.Агаар дуу чимээний шинжилгээний хариу* ........................................ 58
*Зураг 34. Худгийн усны сорьц* ........................................ 60
*Зураг 35. Усны шинжилгээний хариу* ........................................ 61
*Зураг 36.Усны шинжилгээний төлбөр* ........................................ 62
*Зураг 37. Эрсдлийн үнэлгээ хийсэн ажлын тайлан* ........................................ 65

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

*Хүснэгт1. Төслийн ерөнхий мэдээлэл* ........................................ 4
*Хүснэгт 2. Газарзүйн солбицол* ........................................ 5
*Хүснэгт 3. Бутлан ангилах тоног төхөөрөмж* ........................................ 6
*Хүснэгт 4. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт* ........................................ 37

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## *1.1 Төслийн ерөнхий мэдээлэл*

*Хүснэгт1. Төслийн ерөнхий мэдээлэл*

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | “БАТШИЛ” ХХК |
| 2 | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Баянгол дүүрэг, 20-р хороо, Дунд голын гудамж, "Улаанбаатар менежмент" ХХК-ийн байр, 306 тоот<br>Утас: 80003399 |
| 3 | Төслийн нэр | Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн нутагт орших “Бөхөг-3” нэртэй элс хайрганы хольцын ордыг ил уурхайн аргаар ашиглах |
| 4 | Хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт | Улсын бүртгэлийн дугаар:9011355093<br>Улсын регистрийн дугаар:5609372<br>Улсад бүртгүүлсэн: 2012.06.12<br>Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл:<br>Дугаар: MV-016839<br>Олгосон огноо: 2011.05.26 |
| 5 | Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай | Талбай: 42.02 га<br>Газар зүйн солбилцол: (L-48-11) |
| 6 | Ордын геологийн бодит (B) нөөц | 3659.05 мян.$м^3$ |
| 7 | Тусгай зөвшөөрлийн талбайд үлдэх үлдэгдэл нөөц | 2328.5 мян.м3 |
| 8 | Ордын үйлдвэрлэлийн нөөц | 2259.34 мян.$м^3$ |
| 9 | Уурхайн жилийн хүчин чадал | Хүдэр/элс олборлолт: 90.0 мян. $м^3$ |
| 10 | Ордын ашиглалтын хугацаа | 26 жил |
| 11 | Төслийн нийт хөрөнгө оруулалт | 954.3 сая.төгрөг |
| 12 | Жилийн цэвэр ашиг | 216.89 сая.төгрөг |
| | Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа | 3.08 жил |

“Бөхөг-3” элс хайрганы хольцын орд нь MV-016839 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хамаарагдах бөгөөд УБ хотоос шулуунаар баруун урагш

25 км-т, Хан-Уул дүүргийн нутагт Шувуун фабрикаас зүүн урагш 1.5 км-т, Бөхөг голын хөндийд, энэхүү голын зүүн эрэгт, 2009 онд хайгуул хийсэн Бөхөгийн элс –хайрганы ордтой залгаа түүнтэй зүүн талаараа хиллэж оршино.

Ү

## *1.2.Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:*




***Зураг 1. Төсөл хэрэгжих газрын топо зураг***

*Хүснэгт 2. Газарзүйн солбицол*

| № | Өргөрөг | Уртраг |
|---|---|---|
| 1 | 47° 44' 11.75" | 106° 34' 1.27" |
| 2 | 47° 44' 56.78" | 106° 34' 1.27" |
| 3 | 47° 44' 56.78" | 106° 34' 5" |
| 4 | 47° 44' 53.00" | 106° 34' 5" |
| 5 | 47° 44' 53.00" | 106° 34' 10.0" |
| 6 | 47° 44' 50.00" | 106° 34' 10.0" |
| 7 | 47° 44' 50.00" | 106° 34' 16.0" |
| 8 | 47° 44' 47.77" | 106° 34' 16.0" |
| 9 | 47° 44' 47.77" | 106° 34' 18.3" |
| 10 | 47° 44' 14.99" | 106° 34' 18.27" |
| 11 | 47° 44' 14.99" | 106° 34' 8.71" |
| 12 | 47° 44' 11.75" | 106° 34' 8.71" |

*Уурхайн ажиллах горим*

Уурхай нь хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллах ба цаг ашиглалтын итгэлцүүр 0.9 байна гэж үзвэл хоногт нийт 7.2 цаг ажиллах юм. Жилд 5-р сарын 01-нээс 09-р сарын 30 хүртэл нийт 153 хоног ажиллах бөгөөд 133 хоногт нь цэвэр олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаар тооцлоо. Уурхайн жилд олборлох хэмжээг /30 мян.м$^3$/-г уурхайн ажиллах горимд үндэслэн тооцоход хоногийн хүчин чадал 250.5 м$^3$, цагийн хүчин чадал 31.3 м$^3$ байхаар тооцоо гарч байна.

*Уурхайн үндсэн тоног төхөөрөмж*

*Хүснэгт 3. Бутлан ангилах тоног төхөөрөмж*

| № | Тоног төхөөрөмж | Тоо, ш | Марк | Хүчин чадал | Цахилгаан зарцуулалт, квт/цаг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бункер, тэжээгүүр | 1 | Y47-100 | 150 тн/ц | 5 |
| 2 | Ангилагч шигшүүр | 1 | 3YA1237 | 7.5-80 тн/ц | 7.5 |
| 3 | Хацарт бутлуур | 1 | PE-500x750 | 40-110 тн/ц | 45-55 |
| 4 | Конусан бутлуур | 1 | PF-1214V | 40-100 тн/ц | 90 |
| 5 | Тосолгооны шахуурга | 4 | - | 100 тн/ц | 26. |
| 6 | Туузан дамжуулагч - 1 | 1 | W700x16 | 150 тн/ц | 7.5 |
| 7 | Туузан дамжуулагч - 2 | 1 | W700x12 | 150 тн/ц | 7.5 |
| 8 | Туузан дамжуулагч - 3,4,5 | 3 | W600x12 | 80 тн/ц | 7.0 |



***Зураг 2. Тоног төхөөрөмжийн дамжлагын схем***

***Тухайн жилийн уулын ажлын хэмжээ***

Уурхай нь 2024 онд уулын ажлаар 5.63 мян.м$^3$ хөрс хуулж 90.0 мян.м$^3$ дайрга олборлохоор төлөвлөлөө. Үүнд, боловсруулалтанд орохгүй 60 мян.м$^3$ ба боловсруулалтанд орох 30 мян.м$^3$ элс, хайрга байна.

# ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Уурхайн доторх замд хайрга чулуу дэвсэх услах зэргээр тоосжилтыг бууруулах ажил хийгдсэн.
- ✓ Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлсон.
- ✓ Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх
- ✓ Карьерын хананд хэвгийгүйжилт хийж гулсалт нуралтгүй болгон, урсгал усны үйл ажиллагааны нөлөөллөөр элэгдэл эвдрэл үүсэхээргүй болгон тогтвортой байдлыг
- ✓ Хэлбэржүүлж зассан талбайг тухай бүр шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлтгэх
- ✓ Шимт хөрсний овоолго хийж хадгалсан.
- ✓ Уурхайн зам талбайд тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.
- ✓ Уурхайн автомашины хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах үүднээс карьер зам дээр хайрга асгаж тэгшилсэн.
- ✓ Аюулгүй ажиллагааны самбаруудыг зохих байршлуудад байрлуулсан.
- ✓ Усны эх үүсвэрийг тоолууржуулах, усны төлбөрөө тогтмол төлсөн. /Санхүүгийн баримтыг хавсаргав/
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, зөөж тээвэрлүүлсэн /Санхүүгийн баримтыг хавсаргав/



***Зураг 3. Орчины сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд тээврийн хэрэгсэл явах карьерийн зам дээр хайрга асгаж тэгшилэх ажилын явц***

Ажилчдын байр, амьдрах орчныг сайжруулах хүрээнд байрны гадна фасад, дулаалга, дотоод тохижилт хийгдсэн. Мөн усанд орох дууш, бохир усны цооног шинээр хийж, ариун цэврийн нөхцөлийг сайжруулсан





***Зураг 4. Ажилчдын байрыг засварлаж сайжруулсан***



***Зураг 5.Цайны газрын хуучин шинэ байр***




***Зураг 6.Ажилчдын усанд орох душ барьж байгаа ажлын явц***

2025 оны 1 сарын 6-нд Хан-уул дүүргийн засаг дарга Б.Цэрэн болон Батшил ХХК-ийн Д. Төгсөө нар нэг жилийн хугацаатай Ус ашиглах гэрээ байгуулсан. Тус гэрээ болон ус ашиглах эрхийг бичиг, усны төлбөр төлсөн баримтын хамт доор үзүүлэв.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
А-367 дугаар тушаалын хавсралт

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
.............. Б.ЦЭРЭН

БАТЛАВ
"БАТШИЛ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
.............. Д.ТӨГСӨӨ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 01 сарын 06-ны өдөр    Дугаар 9/46    Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1 дэх хэсэгт заасны дагуу Нийслэлийн Байгаль Орчны Газрын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 2024/101 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн "Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай" А/453 дугаар захирамжийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Г.Туяацэцэг, ус ашиглагчийг төлөөлж нийслэлийн Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Бөхөг-3 газарт 9011355093 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5609372 регистрийн дугаартай "Батшил" ХХК-ийн захирал Д.Төгсөө нар ус ашиглах талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. **Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт:** Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулдаг. Унд ахуйн усан хангамж, гудамж талбайн тоосжилт дарах, зүлэг ногоо услахад усыг авч ашиглана.

2.2. **Ашиглах усны хэмжээ**

2.2.1. Унд ахуй 10.8 $м^3$
2.2.2. Үйлдвэрлэл
2.2.3. Үйлчилгээ

2.3. **Усны чанар, найрлага:** "Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018"-ын шаардлага хангаж байна.

2.4. **Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо метрээр/:** 45 метрийн гүнтэй, 1 л/с ундаргатай худагтай. Ундаргаар нь тооцож үзэхэд хоногт дунджаар 86.4 $м^3$ ус авч ашиглах боломжтой. Хоногт дунджаар 10.8 $м^3$ ус авч ашиглаж байна.

2.5. **Байршил:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 13 дүгээр хороо, Бөхөг-3

**Солбилцол:** 47°44'56.78"N, 106°34'5.00"E

**Барилга байгууламж:** Гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.

**Тоног төхөөрөмжийн нэр, марк, хүчин чадал:** Жилд 30.0 мян.м3 элс, хайрга олборлодог. 5 сараас 9 сар хүртэл 153 хоног ажилладаг. 17 ажилтан алба хаагчтай.

2.6. **Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:** Унд ахуйгаас гарах хаягдал бохир усыг хөрсөнд шингээж байна.

2.7. **Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:** Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2020 онд "Монслов" ХХК-аар хийлгэж БОАЖЯ-аар батлуулсан.

2.8. **Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур, насосны хүчин чадал, марк:** Худагт стандарт, хэмжилзүйн газраас 2022 оны 08 дугаар сард баталгаажуулсан. СХВ загварын, 0.15 мм-ийн голчтой, гэрчилгээний 49870992 дугаартай. 2022 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн заалт. 01340м3

2.9. **Онцгой нөхцөл:**

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А/230/127 дугаартай тушаалаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсврийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх



журмын 3.18 дах заалтад заасны дагуу эрүүл ахуйн хориглолтын бүсийг байгуулан мөрдөж ажиллах.

- БОНБНҮ-ний тайланд устай холбогдуулан өгөгдсөн зөвлөмжүүдийг биелүүлэх.
- Үнд ахуйгаас гарсан ахуйн бохир усыг хөрсөнд хаяхдаа Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартад нийцүүлэн хаях шаардлагатай.

2.10. **Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:** "Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн төлбөрийг төлнө.

**1м³ усны нөөц ашигласны төлбөр 9440 төг/м³*0.07*15%/100%/=99.12 төг**

Нийт төлбөр болох 56,503.4 болон усны тоолуураар гарсан төлбөрийг хугацаанд нь төлөх

**Гурав. Талуудын эрх, үүрэг**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**Ус ашиглуулагчийг төлөөлж:**
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
Г.Туяацэцэг

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Хог хаягдлын менежмент, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн
Б.Эрдэнэзул

Хаяг: ХУД-ийн 20 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байр 4 давхар 402 тоот

**Ус ашиглагчийг төлөөлж:**
Захирал
Д.Төгсөө



Хаяг: Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Бөхөг-3

Утас: 80003399

ГЭРЭЭ ХЯНАСАН

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ОЧИР

*Зураг 7. Ус ашиглах гэрээ*



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-157 тоот тушаалын 2 дугаар хавсралт

УС АШИГЛАХ ЭРХИЙН БИЧИГ

Дугаар №22/04

Нийслэлийн Байгаль орчны газар -ын
/Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба/
гаргасан 20 21 оны 08-р сарын 25-ны өдрийн 2022/28 дугаартай ус ашиглуулах дүгнэлт,
Хан-Уул дүүргийн Засаг дарга -ын
/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга/
олгосон 20 22 оны 09-р сарын 05-ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл,
Хан-Уул дүүргийн Засаг дарга -тай
/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга, Ус хангагч байгууллага/

20 22 оны 08-р сарын 25-ны өдөр байгуулсан 9/35 дугаар бүхий ус ашиглах гэрээг үндэслэн Улаанбаатар аймаг, нийслэл, Хан-Уул сум, дүүрэг 13 баг, хорооны
/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хаяг/
нутагт байршилтай, улсын бүртгэлийн 9011355093 тоот гэрчилгээтэй, 5609372 регистрийн дугаартай "Батшил" ХХК -г
/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр/
ус ашиглахад тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж, Бөхөг -3 газарт байршилтай усны нөөцөөс хоногт 10,8 шоо метр усыг
/гадаргын ус, газрын доорхи ус/
Унд, ахуй үйлдвэрлэл зориулалтаар ашиглах ЭРХИЙН БИЧИГ-ийг гурван жилийн хугацаагаар олгов.

Эрхийн бичиг олгосон:

ХУД, ЗДТГ-ын Хог, орчны бохирдол зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Алтангэрэл
аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Байгаль хамгаалагч
/Байгууллага, албан тушаалтны нэр, гарын үсэг/

20 22 оны 09-р сарын 05-ны өдөр

*Зураг 8. Ус ашиглах эрхийн бичиг*

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2024 оны 10 сарын 31 өдөр Дугаар 2024/101 Улаанбаатар хот

"БАТШИЛ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ТӨГСӨӨ ТАНАА

1. **Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:** "Батшил" ХХК, захирал Д.Төгсөө, Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Бөхөг-3, Утас:80003399, Улсын бүртгэлийн дугаар 9011355093, регистрийн дугаар 5609372.
2. **Төслийн байршил /ХӨ;ЗУ/:** Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Бөхөг-3 MY-016839, 47°44'50.1"N, 106°34'12.0"E.
3. **Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:** Хан-Уул дүүргийн нутагт орших Бөхөг-3 нэртэй талбайд элс хайрганы хольцын ордыг ил уурхайн аргаар олборлодог.
4. **Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:** Жилд 30.0мян.$м^3$ элс, хайрганы хольц олборлодог. Жилд нийт 153 хоног 17 ажилтан ажилладаг.
5. **Үйлдвэрлэх боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:** Жилд дунджаар 30.0мян.$м^3$ элс хайрганы хольц олборлоно.
6. **Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:** Ундаа ахуйд зориулан гаргасан 60м гүнтэй 1 худагтай. Худгийн паспортод тэмдэглэсэн ундаргаар тооцоход 86.4$м^3$ усыг хоногт ашиглах боломжтой.
7. **Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:** Ус хангамжийн зориулалтаар гаргасан гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.
8. **Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк/:** Худагт QJD 1.1-3 маркийн насосыг 50м гүнд байрлуулсан бөгөөд СХВ загварын, 15мм-ийн голчтой, 0200506811 дугаартай хүйтэн усны тоолуурыг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр суурилуулсан. Тоолуурын заалт 00109$м^3$.
9. **Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр, эх үүсвэр/.** Өрөмдмөл худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.
10. **Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний 2020 онд боловсруулагдсан тайланд "бохирын цооногт хуримтлуулан, тогтмол хугацаанд соруулан тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр зөөвөрлөн бохирын системд нийлүүлнэ" гэж тусгасан.

11. **Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:** Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2020 онд "Монслов" ХХК-иар хийлгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан. Нарийвчилсан үнэлгээнд заасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

12. **Онцгой нөхцөл:** Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд /хуучин нэрээр/, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаартай тушаалаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.18 дах заалтад заасны дагуу эрүүл ахуйн хориглолтын бүсийг байгуулан мөрдөж ажиллах.

13. **Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:** "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 3,14 дүгээр хавсралтаар усны зарцуулалтыг тооцвол:
    - 1 ажилтан алба хаагч хоногт 50 л ус ашиглана гэж үзвэл: 14 ажилтан алба хаагч 1 хоногт 0.85м$^3$, 153 хоногт 130.05 м$^3$ ус;
    - 1 м$^2$ талбайн тоосжилт дарахад 2л ус ашиглана гэж үзвэл: 5000м$^2$ талбайн тоосжилт дарахад 10м$^3$ ус ашиглах бөгөөд 7 хоногт 2 удаа буюу нийт 44 удаа услахад 440м$^3$;

**Нийт 570.05м$^3$.**

14. **Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:** "Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай", "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн төлбөрийг тооцоход:

**1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр 9440 төг/м$^3$*15*0.07/100%= 99.12 төг**

9440 төг/м$^3$ – Экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
15% - Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;
0.7 - Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр;

570.05 м$^3$ *99.12 төг=56,503.4 төг /Тавин зургаан мянга таван зуун гурван төгрөг дөрвөн мөнгө/

15. **Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаархи зөвлөмж:**

- Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газартай 2024 оны ус ашиглах гэрээг байгуулах.
- Гүний худгийн уснаас дээж авч бактериологийн шинжилгээ хийлгэх ба усны стандартын шаардлага хангасан тохиолдолд унд ахуйд ашиглах.
- 2024 оны усны нөөц ашигласны төлбөрийг тоолуурын заалтаар тооцож Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн дансанд 12 дугаар сарын 25-ны дотор төлөх.
- Жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тухай оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж байх. Дүгнэлтэд заасаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр

тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцохыг анхаарах.

- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу бохир ус хаях зайлуулах дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаанаас авах.
- Тоолуурын заалтын баталгаа алдагдсан, шугам хоолойгоос салгасан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцож оногдуулахыг анхаарах.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэлттэй байдлаар ашиглах шаардлагын хүрээнд ариун цэврийн өрөө, шүршүүрт мэдрэгчтэй төхөөрөмж суурилуулж усыг хэмнэх.
- Хур бороо цас мөсний усыг хуримтлуулж ногоон байгууламж, зам талбайн усалгаанд хэрэглэх.

ДАРГА Р.ЭНХТАЙВАН

*Зураг 9.Ус ашиглуулах дүгнэлт*

Бохир усны менежментийн энэхүү ажиллагаа нь “Батшил ХХК”-ийн 2025 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчны хамгааллын бодлогын биелэлтийн нэг хэсэг юм. Тогтмол хяналт, цэвэрлэгээ хийх нь хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлж, ажилчдын эрүүл ахуйг хамгаалах чухал нөхцөл болдог.

“Батшил” ХХК

БАТШИЛ ХХК

“Олоннугалаа” ХХК

УЛААНБААТАР ХОТ

ОЛОННУГАЛАА ХХК

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот | Дугаар 25/01 | 2025 он 3 сар 11 өдөр

Энэхүү гэрээг нэг талаас Батшил ХХК /5609372/ регистерийн дугаартай хуулийн этгээд төлөөлөн Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 13-р хороо, Бөхөг-3 хаягтай Гүйцэтгэх захирал Дүгэр овогтой Төгсөө, Нөгөө талаас Олоннугалаа ХХК /5277248 / Сонгинохайрхан дүүрэг, 40-р хороо, баянхошуу 40-8 тоот Монгол улсын холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон байгуулав.

**1.Гэрээний зүйл**

1.1. Гүйцэтгэгч нь захиалагчид энэ гэрээний хавсралтанд дурдсан Тусгай зориулалтын машинаар шингэн хог хаягдал ачиж зөөвөрлөх ажил гүйцэтгэнэ үүргийг хүлээнэ.
1.2. Гүйцэтгэгч, захиалагч ба түүнтэй гэрээ байгуулагчийн хооронд тохиролцож болох гэрээний нөхцөл болон уг тохиролцооны томъёололыг боловсруулан бэлтгэнэ.
1.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үйлчилгээ үзүүлсний нь төлөө гүйцэтгэгчид ба түүнтэй гэрээ байгуулагчийн хооронд байгуулсан гэрээний үнийн хувьтай тэнцэх хэмжээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**2.Гүйцэтгэгчийн үүрэг**

2.1. Гүйцэтгэгч доорхи үүргийг хүлээнэ.Үүнд:
- Энэ гэрээний хавсралтанд дурдсан байгаа Тусгай зориулалтын машинаар шингэн хог хаягдал ачиж зөөвөрлөх машин техникийг зөөвөрлөнө.
- Захиалагч ба гэрээ байгуулагчдын хооронд төлөөлөгчдийн хооронд уулзалт, хэлэлцээр зохион байгуулах
- Захиалагч гэрээ байгуулагчдийн хооронд харилцан ашигтай гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх
- Гэрээний хугацаа 1 жил болно.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
- Кемпид дотоод журамыг мөрдөж ажилна.
-Тусгай зориулалын машиныг уул уурхайн бүсэд нэврэхдээ хөндлөх зам болон отвол руу нэвтрэхдээ ХАБЭА-ын журамыг хангасан байх болно.

**3.Захиалагчийн үүрэг**

3.1.Захиалагч доорхи үүрэг хүлээнэ.Үүнд: 2025-с эхлэн улирал бүр хугацаанд нэг удаагийн бохир соруулалтын төлбөр нь НӨАТ-тэй үнэ 220 000төгрөг байна хөлсийг улирал бүр тогтмол төлж байна
- Гүйцэтгэгчид түүний энэ гэрээнд заасны дагуу санал болгосон талтай байгуулсан






*Зураг 10.* ***Мэргэжлийн байгууллагаар бохир ус соруулж*** *тээвэрлэсэн*



Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/719/189 дүгээр тушаалын хавсралт

ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: №22/04

Туул голын сав газрын захиргаа -ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /

20 21 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах ХУД 22/100 -от дүгнэлтийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэл Баянгол сум/дүүргийн 20-р хороо, УБМ-БҮК-ийн 312 тоот байршилтай
/ хаяг /

Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт
/ үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа "Батшил" ХХК -д
/ хүн, хуулийн этгээдийн нэр /

Улаанбаатар аймаг/нийслэл, Хан-Уул сум/дүүргийн 13-р хороо, Бөхөг-3 байршилтай хаягдал ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугамд жилд 113,0 мян.м³ хаягдал усыг "Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015", "Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг
/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно. Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

ХУД-ИЙН ХОБЗХ-ийн дарга / Зөвшөөрөл олгосон байгууллага / ...... / Гарын үсэг / /Ц.Алтангэрэл/ / Гарын үсгийн тайлал /

Тамга

20 22 оны 09 -р сарын 05 -ны өдөр

*Зураг 11. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл*

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2019 оны А/634 тоот тушаалын хавсралт

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
.................... Б.ЦЭРЭН

БАТЛАВ
"БАТШИЛ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
.................... Д.ТӨГСӨӨ

ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2025 оны 01 сарын 06-ны өдөр                Дугаар 9/45                Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу Туул голын сав газрын захиргааны гаргасан 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Е-2410-000173 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Ганболд овогтой Туяацэцэг, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, БҮК ХК-ний байранд байрлах 9011355093 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5609372 тоот регистрийн дугаартай "Батшил" ХХК-ийг төлөөлж захирал Д.Төгсөө нар ус бохирдуулсны төлбөр, нэмэгдэл төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын нормтив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын нормтив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.3.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.3.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.3.5. Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.3.5. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно;

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохидуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны зарцуулалтыг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, зэврэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрыг төлөөлж:**

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
Г.Туяацэцэг

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Хог хаягдлын менежмент, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн
Б.Эрдэнэзул

Хаяг: ХУД-ийн 20 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байр 4 давхар 402 тоот

**“БАТШИЛ” ХХК-ийг төлөөлж:**

Захирал
Д.Төгсөө

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Дунд голын гудамж, УБМ-БҮК-ийн байр, 312

Утас: 80003399

ГЭРЭЭ ХЯНАСАН:

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ОЧИР

*Зураг 12. Хаягдал ус зайлуулах гэрээ*

# ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ

MV-016839 0,4 га талбайд олборлолт хийгдсэн газар байгаль орчны сөрөг нөлөөлөлийг бууруулах газрын хэвлийг нөхөн сэргээж дараагийн үе шат болох биологийн нөхөн сэргээх суурийг бэлдэх зорилгоор ачигч техник , самосвал ашиглан ухаш нүхийг шороогоор дүүргэн тэгшилэн налуулах ажлыг гүйцэтгэсэн. Ингэснээр биологийн нөхөн сэргээлтийн бэлтгэл болон ургамал үрийг хөрсөнд тарих ажлын эхний үе шат хийгдсэн.





*Зураг 13.Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байдал.*






*Зураг 14.бэлтгэл ажил үр цацах ажилын хэсгээс*








***Зураг 15.Биологийн нөхөн сэргээлт хийсэн байдал***

## ОРОН НУТГИЙН ЗАМЫН ЭВДРЭЛ ГЭМТЭЛ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Хүнд машин механизм (ачигч,самосвал) ашиглан эвдэрсэн хэсгийн хайрган дүүргэлт, хөрсний тэгшилгээ хийгдэв. Замын гадаргуугийн ус тогтсон хэсгийг шороогоор дүүргэн замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж, тээвэрлэлтийн нөхцөлийгсайжруулсан.





***Зураг 16.Орон нутгийн замын эвдрэлийг засварлаж тэгшилж байгаа ажлын явц.***

# ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгааллын арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Зардал мян.төг | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|
| **Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх** | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд НБОГ-аас зохион байгуулаж буй ажилд оролцох | - | Үйл ажиллагааны зардал | БОННҮ-ний аргачлал, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага |
| Нийт | - | - | - | |

100 ширхэг суулгац талбайдаа тарьж, ойжуулах үйл ажиллагааг дэмжиж ажилласан.





*Зураг 17. Мод тарьсан байдал*

## ТАВ.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний ажил төлөвлөгдөхгүй болно.

## ЗУРГАА.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашиглалтын талбайн хэмжээнд түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй.

## ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Батшил ХХК нь хог хаягдлын гэрээг байгуулж, хог хаягдлын цэгийг ангилан ялгах боломжтой байдлаар зохион байгуулсан.Хог хаягдлыг тогтмол зайлуулж төлбөрийг төлсөн. Хог хаягдлын цэг болон гэрээ, баримтыг доор үзүүлэв.




***Зураг 18. Хог хаягдлын цэг***

**БАТЛАВ.**
**“ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК-ИЙН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**
........................
**Ө.ОДОНСҮРЭН**

**БАТЛАВ.**
**ЗАХИРАЛ**
........................
**Д.ТӨГСӨӨ**

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2025 оны 09-р сарын 19-ны өдөр № 8-АШГ-010/25 Улаанбаатар хот

Энэхүү “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ” /Цаашид “Гэрээ” гэх/-г,
Нэг талаас Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, Ханну төв, 500 тоот хаягт байрлах, 6352901 тоот регистрийн дугаартай “ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК, /Цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх Ө.Одонсүрэн ,

Нөгөө талаас Монгол улс, Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Нарангын 11-35 тоот хаягт байрлах, “Батшил” ХХК (РД: 5609372), (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж захирал Д.Төгсөө нар /Цаашид хамтад нь “Талууд” гэх/

Монгол улсын “Иргэний хууль”, “Хог хаягдлын тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам” болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ийн зүйл, заалтыг үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээгээр захиалагч нь “аюултай хог хаягдал” болох “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г дахин боловсруулж, устгуулах зорилгоор гүйцэтгэгчид шилжүүлэх, аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс төлөх, гүйцэтгэгч холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тээвэрлэж, өөрийн үйлдвэрт дахин боловсруулж, устгалд оруулахтай холбоотой талуудын хоорондын харилцаа болон эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулна.
1.2. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журамд зааснаар зохицуулна.
1.3. Талууд гэрээний хугацаанд хавсралтад заасан маягтын дагуу “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг” /Хавсралт-1/-ийг үйлдэх бөгөөд энэхүү дагалдах бичиг нь гэрээний салшгүй хэсэг байна.

1

**Хоёр. Гэрээний хүрээнд хамтран ажиллах нөхцөл**

2.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн ажилтнуудыг “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г эх үүсвэр дээр түр хадгалахтай холбогдох аюулгүй ажиллагаа, хар тугалгын батарейг бусад төрлийн батарейнаас таньж мэдэх аргачлал зэрэг сэдвээр үнэ төлбөргүй зааж сургаж, гарын авлагаар хангаж болно.
2.2. Гүйцэтгэгч нь “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г захиалагчаас хүлээн авахдаа зөвхөн хар тугалгын батарей эсэх, батарейнаас өөр төрлийн эд зүйлс байгаа эсэхийг шалгаж, өөрийн зориулалтын тээврийн хэрэгсэлд жинлэн хүлээн авч, тээвэрлэнэ.
2.3. Захиалагч хүссэн нөхцөлд гүйцэтгэгчийн зүгээс “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г зориулалтын хадгалах саваар хангаж болно.
2.4. Захиалагч нь өөрт цугларсан батарейны мэдээллийг тухай бүр гүйцэтгэгчид мэдээлж, гэрээний хүрээнд батарейг шилжүүлэх захиалга тухай бүр өгч ажиллана.

**Гурав. Талуудын эрх, үүрэг**

3.1. Захиалагч дор дурдсан эрхтэй байна. Үүнд:
3.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, зохих ёсоор, бүрэн гүйцэтгэхийг гүйцэтгэгчээс шаардах;
3.1.2 “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г тээвэрлэх, хадгалах болон дахин боловсруулж, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг гүйцэтгэгчээс шаардах;
3.1.3. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г шилжүүлэн өгөхдөө жинлэх үед хамт байж, хяналт тавих;
3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7.а дахь заалтад заасан маягтын дагуу “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг”-ийг гүйцэтгэгчээс шаардах;
3.1.5. Хууль болон гэрээнд заасан бусад эрх;
3.2. Захиалагч дор дурдсан үүрэгтэй байна. Үүнд:
3.2.1. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дагуу савлах;
3.2.2. Үүссэн “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г өөрийн салбар нэгжүүдээс нэг цэгт цуглуулан, Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан дагуу эх үүсвэр дээр түр хадгалах;
3.2.3. Захиалагч нь зөвхөн “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г гүйцэтгэгчид шилжүүлэн өгөх;
3.2.4. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г хүлээлгэн өгөхдөө “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг”-т өөрт холбогдох хэсгийг үнэн зөв бөглөх;
3.2.5. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г гүйцэтгэгчид шилжүүлэх хүртэл түүний аюулгүй байдлыг хадгалж, хамгаалж, түүнээс үүсэх аливаа эрсдэлийг бүрэн хариуцах;
3.2.6. Шилжүүлэн өгсөн “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-ны тээвэрлэлт болон устгуулсан үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах;

2

3.2.7. "Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей"-г шилжүүлэх захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтныг аюултай хог хаягдлыг ачих цэгт байлгаж, ачилтанд хяналт тавих;
3.2.8. Хууль болон гэрээнд заасан бусад үүрэг;
